

Information for parents after a stillbirth

Нярайн эндэгдлийн дараах эцэг эхэд зориулсан мэдээлэл

➤ **Mongolian**

➤ **2020 оны нэгдүгээр сар**

Нярайн эндэгдэл ихэнхдээ гэнэтийн байдаг. Эцэг эх таны хувьд маш их сэтгэлийн зовиуртай үйл явдал юм. Энэхүү мэдээлэл нь та болон таны гэр бүлд хүнд, хэцүү шийдвэрүүдийг гаргахад туслах зорилготой. Таныг хүүхдээ алдсан эсвэл алдах гэж байгаа тухай мэдээг сонсох үед нийгмийн ажилтан таньд дараах зүйлээр тусалж, зааварчлах болно:

- дараагийн хийх алхам
- хүүхэдтэйгээ хамт байх цаг
- дурсамж үлдээх
- оршуулга зохион байгуулах
- санхүүгийн тусламж
- төрсний гэрчилгээ
- задлан шинжилгээ
- хагацал, гашуудал даван туулахад туслах үйлчилгээ

Дараагийн хийх алхам

Таныг эмнэлгийн тусгай ганцаарчилсан өрөөнд оруулна. Эмч, сувилагч, нийгмийн ажилтан нар хүүхдээ хэрхэн төрүүлэх төлөвлөгөөг таньтай ярилцах болно. Эмнэлэгт байх хугацаандаа та нөхрөө эсвэл гэр бүлийн бусад гишүүнийг хажуудаа хамт байлгаж болно.

Хүүхэдтэйгээ хамт байх цаг

Та хүүхдээ харахыг хүсч байж болно. Эмнэлэгийн ажилтан болон нийгмийн ажилтан нар хүүхэд ямар байдалтай байгааг дүрслэн хэлж урьдчилан таныг бэлддэг. Таньд хүүхэдтэйгээ хамт байх цаг хугацааг олгон, эмнэлгийн ажилтан хүүхдийг өлгийнд ороон таньд өгдөг. Олон эцэг эхчүүд ингэснээр гашуудлаа даван туулахад болон дурсамж үлдээхэд тусалсан гэж хэлдэг.

Эцэг эх хүүхэдтэйгээ хэр удаан хугацаанд хамт байхыг өөрсдөө шийддэг. Эмнэлгийн ажилтан тухайн гэр бүлийн хүсэлтийг бүрэн дэмжиж ажиладаг.

Гэр бүлийн бусад гишүүд ч хүүхдийг харахыг хүсч, хайр энэрэлээ илэрхийлж болно. Хэнд хүүхдээ харуулахыг эцэг эх мөн өөрсдөө шийднэ. Та орон нутгийнхаа шашны удирдагч хүнийг авчран ёслол, адислах зан үйл хийлгэж болно. Нийгмийн ажилтан ганцаарчилсан өрөө эсвэл залбирлыг өрөөг таньд бэлдэн, зохион байгуулж туслах боломжтой.

Хүүхэдтэйгээ дурсамж үлдээх

Хүүхэдтэйгээ дурсамж үлдээх нь таньд тайтгарал авчирч болно. Та дурсамжийн хайрцаг үүсгэж болох ба үүнд хүүхдийн жин, уртыг хэмжсэн тэмдэглэл, орон дээрх карт, бугуй дэх оосор, гар болон хөлийн хээ, үсний хэсэг эсвэл фото зураг хийж болно. Мөн та хүүхэдтэйгээ хамт байж усанд оруулах, хувцаслах эсвэл өөрөө зургийг нь дарж авч болно. Эдгээр дурсамжийг үлдээхэд нийгмийн ажилтан таньд туслах болно.

Оршуулга зохион байгуулах

Хэрвээ таны хүүхэд ургийн 20 долоо хоногоос дээш эсвэл хүүхдийн ургийн нас тодорхойгүй боловч 400 граммаас дээш жинтэй бол оршуулга үйлдэх хуулийн шаардлага байдаг.

Олон гэр бүл хүүхдийнхээ амийг хүндэтгэн оршуулах ёслолын үйлчилгээг сонгодог. Таныг оршуулгын зохион байгуулагчаа сонгох хүртэл хүүхэд эмнэлгийн шарил хадгалах өрөөнд байх болно. Оршуулга зохион байгуулагч хүүхдийг эмнэлгээс авах хүртэл та хэдийд ч хүүхэдтэйгээ хамт байж болно.

Оршуулга зохион байгуулагч эндэгдлийн гэрчилгээг бүртгүүлэхээр Registry Office of Births, Deaths and Marriages руу илгээдэг.

Санхүүгийн тусламж

Та оршуулгын үйл ажиллагааг зохион байгуулах болон ажлын амралт, чөлөө авахдаа санхүүгийн тусламж хүсч болно. Таны эх баригч Family Tax Benefit Bereavement Payment болон Maternity Allowance тэтгэмж авах Centrelink-ийн өргөдлийн маягтыг таньд өгөх болно. Асууж тодруулах зүйл байвал та Centrelink-ийн 136 150 дугаар луу залгаж болно.

Төрсний гэрчилгээ

Эх баригч Төрсний Бүртгэлийн анкетийг таньд өгнө. Та анкетийг бөглөөд шуудангаар илгээх эсвэл Төрөлт Бүртгэлийн оффис дээр өөрийн биеэр хүргэж өгч болно. Байршил болон шуудангийн хаяг нь анкетын ар талд байдаг.

Задлан шинжилгээ

Эмнэлгийн багийнхан эндэгдлийн шалгааныг тодорхойлох задлан шинжилгээ хийх сонголтын талаар тантай ярилцах болно. Зарим эцэг эхчүүд эндэгдлийн шалтгааныг удамшлын байх магадлалтай эсэхийг тодорхойлуулахыг хүсдэг. Энэ бол таны шийдвэр. Шинжилгээний үр дүн нь таны асуултанд бүрэн хариулах боломжгүй байх, эсвэл цаг их орох магадлалтай байж болно. Хариу нь гарахаар эмнэлгийн багийнхан тантай цаг товлон шинжилгээний үр дүнг танилцуулдаг.

Гашуудал даван туулахад туслах үйлчилгээнүүд

Red Nose Grief and Loss

Хагацал, гашуудал даван туулахад туслах үйлчилгээ (24 цаг)

Утас: 1300 308 307

www.rednosegriefandloss.com.au

И-мэйл: support@rednose.com.au

Bears of Hope

Жирэмсэн болон Нярайн эндэгдэлд туслах үйлчилгээ

Утас: 1300 114 073

www.bearsofhope.org.au

Sands Australia

Sands Туслах шугам

Утас: 1300 072 637

www.sands.org.au

Хэрвээ Англиар ярьж, ойлгоход тусламж хэрэгтэй бол мэргэжлийн орчуулгын үйлчилгээ авах боломжтой. Таны гэр бүлийн гишүүн эсвэл найз нөхөд хамт байж болох ч тантай холбоотой асуудлаар зөвхөн мэргэжлийн орчуулагчаар дамжуулан харилцана. Орчуулгын үйлчилгээ нь үнэгүй бөгөөд нууцлалын өндөр хамгаалалттай. Хэрвээ таньд энэ үйлчилгээг санал болгоогүй бол та өөрөө орчуулгын үйлчилгээ хүсэх эрхтэй. Манай ажилчид таньд орчуулагчийг захиалж өгнө.

2017 оны 12 дугаар сард St George Hospital эмнэлгийн Хэрэглэгч Зөвлөлийн Группээр хянан нягтлуулав.